

**ЦАГААН ОВООНЫ ЭРТНИЙ ТҮРЭГ БИЧЭЭСИЙГ
ДАХИН НЯГТЛАХ НЬ**

Хасбаатар*

Эртний Түрэг угсаатнууд VI зууны дунд үеэс Монголын өндөрлөгт ноёрхон сууж, “зүүн тийш Ляо далай, баруунш Баруун далай, өмнө зүгт элсэн цөл буюу их говь, хойш умард тэнгис буюу Байгаль нуур”¹ хүртэлх газарт хүчирхэг их Түрэгийн хаант улсыг байгуулсан юм. Хятадын Умард Чи (北齐), Умард Жоу (北周) хоёр улсын хооронд дайн үүсэхэд², тэд бүх эд хөрөнгөө Түрэгийн хаант улсад өргөн барьж, тэдний дэмжлэгийг хүсч байснаар үл баран, Сүй улс (隋朝)-ын сүүл үед³ нийт хятад газрыг хамарсан их үймээн дэгдэхэд, хятадын умард орны адил бус газрын ноёрхогчид цөм Түрэгийн хааныг өөрийн хаанаар үзэн дээдэлж байсан юм. 618 онд Сүй улсын ноёрхлыг эсэргүүцэж бослого гаргасан Ли Юань (李渊)-ийг дэмжин Тан улс (唐朝)-ыг байгуулсан билээ. 630 онд Түрэг хаант улс дотоодын самуурал болон хятадын Тан улсын дайллагын улмаас мөхөж, тэдний ихэнх нь урагш нүүдэллэн, Хатан голоос хойш, элсэн цөлөөс өмнөшхи газарт(даруй одоогийн Өвөр Монголын баруун бие) нутаглажээ. 682 онд Түрэгийн хааны угсаа болох Кутлуг(Qutluy) Тан улсын эсрэг бослого гарган Түрэгийн II хаант улсыг байгуулсны эхний хэдэн жилд одоогийн Өвөр Монголын Муна уулын ар бие Чугай уулаар суурилж, дараа нь хойш цэрэглэн Түрэгийн ноёрхлын төв нутаг болох Этүгэн газарт /Орхоны хөндий/ буцсан билээ. 745 онд Түрэгийн II хаант улс тэдэн лүгээ гарал нэг Уйгурын дайралтад мөхөв.

Эртний түрэгүүд үнэлж баршгүй үлэмж олон соёл, түүхийн өвийг бүтээсний дотор өнөөг хүртэл үлдэж ирсэн эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй зүйлд эртний түрэг бичээсүүд орох нь дамжиггүй. Эдгээр бичээсүүд одоогийн Монгол улс, Оросын Холбооны улс, БНХАУ болон Төв Азийн зарим орнуудын нутгаас олдсон байдаг. Одоогийн Өвөр Монгол орон мөнхүү Түрэгүүдийн нутагшин байсан газрын хувьд эдүгээ хүртэл түрэг бичээс олноогүй байсан нь судлаач эрдэмтдийн анхаарлыг татсаар байна.

* БНХАУ-ын ӨМИС-ийн Монгол Судлалын Төв, e mail: khasbaatar@hotmail.com

¹) 《周书》(第三册)卷50《异域传》下突厥, 中华书局, 1971, 第909页。

²) VI зууны сүүлийн хагас.

³) 581-618 оны хооронд тогтнож байсан улс.

2010 оны зун зохиогчоос ӨМИС-ийн Бао Вэнь Шэн (包文胜) нарын хамт Өвөр Монголын Бугат хотын Дархан Муумянган холбоот хошууны нутгаар түрэгийн үеийн үлдэгдэл буурийг судлан байцаахад, тус хошууны ахмад судлаач Мөнхдэлгэр гуай бидэнд өөрийнхөө хэдэн жилийн өмнө хөдөөгүүр хадан зураг судлан явж байхдаа авсан нэгэн гэрэл зургаа харамгүй үзүүлсэн юм. Эдүгээ энэ зураг нэгэнт хэвлэгдэн олны хараанд орсон байна.⁴ Зургийг хараад хадан дээр сийлсэн бичиг нь эртний түрэг бичиг мөн болохыг ухаарч, Мөнхдэлгэр гуайн заасан газруудаар хэдэнтээ хайсны эцэст сая гэрэл зураг дахь бичээст хадыг олсон билээ. Мөнхдэлгэр гуай энэхүү бичээсийг “Цагаан овооны эртний түрэг бичээс” хэмээн нэрлэснийг бид тус өгүүлэлд “Цагаан овооны бичээс” гэж товчлох ба бичээст хадны гэрэл зургийг өгүүллийн хойно хавсаргав.

Газрын байршил: Уг бичээс нь Дархан муумянган холбоот хошууны төв Батхаалга балгасаас зүүн хойш 45 км-т байх Цагаан Овоо сум (одоогийн Дархан сум)-ын Алтантуг гацааны Ширүүн хэмээх газар, N 41°55'26", E 110°46'46" солбилцлын цэгт, далайн төвшнөөс дээш 1362 м өндөрт буй.

Уг хад нь гурван хэсэг боржин чулуунаас бүрэлдсэн (хавсралт зураг 1) бөгөөд бичээс нь давхарлан буй зүүн талын хоёр чулууны доод чулууны зүүн хөвөөг дагуулан дороос дээш чиглэлтэй бичсэн 11 үсэг ба үсэг бүрийн дундаж өндөр нь 4-6 см, өргөн нь 1-5.5 см байж, бичээсийн нийт урт нь 60 гаруй см. Бичээс бүхүй чулууны баруун дээд биед хэсэг хадны сүг зураг буй. Үүнээс 2 янгирын дүрс тодорхой харагдах ба бусад нь он цагийн уртад баларч ором төдий л үзэгдэнэ. (хавсралт зураг 2)

Өмнөх судлаачдын тайлж уншсан ба тэдний санал: “Цагаан овооны бичээс” бол Өвөр Монголоос олдсон анхны бичээс бөгөөд Түрэг угсаатны түүх соёлын судлалд их ач холбогдолтой. Энэхүү бичээс нь шинэхэн олдсон бичээс учраас түүнийг тайлж уншиж судалсан эрдэмтэд төдий л олон биш. ӨМИС-ийн доктор Бай Юй Дун (白玉冬) уг бичээсийг уншиж тайлаад япон, хятад хэлээр хоёр өгүүлэл бичиж хэвлүүлсэн байдаг.⁵

Тус өгүүлэлд бичээсийг тайлж уншсан ба орчуулснаас үзэхэд доктор Бай Юй Дун бээр уг бичээсийг “**qurčī b(ä)nsig(i)m**” хэмээн галиглаж, “**морьт цэрэг над шиг**” хэмээн тайлан уншиж орчуулжээ. Гэвч түүний уншлагад мадагтай хоёр зүйл буй. Тухайлбал:

1. Уг бичээсийн эхний 5 үсгийг “**qurčī**” хэмээн уншиж “**бүс бүсэлсэн хүн**” гэж тайлсан байтлаа, “**морьт цэрэг**” гэж тайлбарласан нь сонирхолтой бөгөөд сэжиглэлтэй. Учир нь “**qur**”-ыг “**бүс**” хэмээн орчуулах нь зөв байж болно. Учир нь Mahmud-al-Kashgari⁶ болон Clauson-ы толь бичиг⁷т тэмдэглээстэй. Гэхдээ “**бүс**” хэмээх утгатай үгийг цааш “**морьт цэрэг**”-тэй холбох нь нотолгоо баримтгүйн дээр ерийн мэдлэгт ч таарахгүй зүйл.

⁴) 孟克德力格尔:《达尔罕茂明安联合旗历史文化遗迹》, 内蒙古人民出版社, 2010, 第41页

⁵) Bai, Yudong: A translation of the čayan obuy-a inscription written in the Turkic Runic script discovered in Inner Mongolia (Japanese), Quaestiones Mongolorum Disputatae VI, International Association for Study of Mongolian Cultures, Tokyo, 2010, p173-187; 白玉冬、包文胜:“内蒙古包头市突厥鲁尼文查干敖包铭文考释——兼论后突厥汗国‘黑沙南庭’之所在”,《西北民族研究》, 2012年第一期, 第78-86页。

⁶) 麻赫默德·喀什噶里:《突厥语大词典》(第一卷), 民族出版社, 2002, 第345页。

⁷) G. Clauson, An etymological dictionary of pre-thirteenth-century Turkish, Oxford, Oxford University, 1972. P-642.

Эртний түрэгүүд нь монголчуудаас өмнө Монголын өндөрлөгт оршин амьдарч байсан нүүдэлчин угсаатан. Нүүдэлчдийн нийгэм ахуйд адуу маш их үүрэг гүйцэтгэдэг. Тиймдээ ч морины зүсэм, бие бялдар зэргийн ялгаанаас улбаалан эртний түрэгүүд морийг олон янзаар нэрлэдэг байсан нь бий. Жишээлбэл: at, adүйr, yont, үйлqī гэх мэт. Ийм байтал морьт цэргийг “*бүс*”-ээр төлөөлүүлэн нэрлэх нь ямар ч боломжгүй зүйл.

2. Тэрээр мөн уг бичээсийн 6, 7-р үсгийг тайлж уншихдаа: “...сийлэх явцын алдаанаас болж *байр нь солигдсон*” гэж үзээд 6, 7-р үсгийн байрыг нь сольж, 6-11 хүртэлх үсгийг нийтэд нь “*b(ä)nsig(i)m - над шиг*” хэмээн уншсан нь үнэхээр гэнэн зүйл. Монголын өндөрлөг болон Төв Азиас олдсон хэдэн зуу, мянга, цаашилбал түмэн үсэгтэй томоохон хөшөөний бичигт ч үг үсгийн алдаа зөрүү гараагүй байхад, 11-хэн үсгээс бүрдсэн бичээст алдаа гарна гэдэг нь даанч итгэмээргүй. Цаашилбал тэрээр “-sig-” дагаврыг монгол хэлний “*шиг*” мөн хэмээн тайлсан нь ч баримтаар аанай билээ. Бидний үед олдоод байгаа хөшөөний бичигт дээрх монгол хэлний “*шиг*”-ийг эртний түрэг хэлний “-sig”-ээр бус, харин “*täg*”-ээр илтгэсэн байдаг. Жишээлбэл: Тоньюкук-ийн гэрэлт хөшөөний 1-р чулууны өмнө талын 8-р мөрт буй “*yaγimiz tägrä ucuq täg ärti biz aη täg ärtimiz*”⁸; Куль-Тегиний гэрэлт хөшөөний зүүн талын 12-р мөрт буй “*...qanim qayan süsi böri täg ärmis̄ yaγis̄i qony täg ärmis̄*”⁹. Von Gabin өөрийн бүтээлдээ “-sig, -siγ”-ийг монгол хэлний “... шиг, ...-тай адил” гэдэгтэй утга нэг хэмээн хэлсэн боловч, өөрийн нь татсан жишээ оновчгүй, илт ташаарсан байдаг.¹⁰

Бичээсийг дахин сэргээж уншсан нь :

Дээрх эргэлзээ төрүүлэм шалтгааны улмаас бид бичээс оршин буй газарт олонтаа очин байцааж, мөн буулгасан гэрэл зургуудыг баримтлан уг бичээсийг дахин сэргээн уншив.

Үүнд:



⁸) 耿世民: 《古代突厥文碑铭研究》, 中央民族大学出版社, 2005, 第 96 页。

⁹) 耿世民: 《古代突厥文碑铭研究》, 中央民族大学出版社, 2005, 第 96 页。

¹⁰) 冯·加班著, 耿世民译: 《古代突厥语语法》, 内蒙古教育出版社, 2004, 第 56 页。

Бичээсийн эх: mGtibNicroK

Үсгийн галиг (transliteration): m g t i b n i ċ R W Q

үгийн галиг (transcription): qur(i)čġn bit(i)g(i)m

Монгол хэлний орчуулга: “Сахигчийн бичиг минь” буюу “Сахигч миний бичиг”

NicroK - qur(i)čġn: Үгийн үндэс нь “**qur-**” - *төвлөрүүлэх, бүслэх, хүрээлэх* гэсэн утгатай байснаас утга нь шилжиж *хамгаалах, сахих, нум сум, бүс* зэрэг утгыг илтгэх болсон билээ¹¹.

- **ġ** - : XIII зууны Монгол хаант улс болон Их Юань улсын үед энэ үг ноёны зэрэг болсон байдаг. “ġ” гэгч тухайн ажлыг хийгч нэр үг буюу үйл үгээс нэр үг бүтээх дагавар. qur-ын ард залгавал qur(i)čġ болон сахигч гэх утгыг илтгэнэ. Үг бүтэх иймэрхүү хэлбэр эртний түрэгийн сурвалж бичиг болон монгол хэлнээ үлэмж тохиолддог. Тухайлбал: Эртний түрэгийн бусад хөшөөн бичигт гардаг *уāgġi-замч, газарч*,¹² *tuġġi-тугч*,¹³ *buġuġi- бүрээч*,¹⁴ *bitigġi- бичээч*¹⁵; XIII зууны Монголын хэшигтэн цэрэг дэх *siba’uchi* (昔宝赤) - *шувууч*; *jarliqchi* (札里赤)- *зарлигч*; *bichikchi* (必闍赤) - *бичээч*¹⁶ зэргийг дурдаж болно.

“-n” - Харъяалахын тийн ялгалын нөхцөл. Эртний түрэгийн сурвалж бичгүүдэд харъяалахын тийн ялгалыг олонхидоо “-ŋ (буюу -n°ŋ)”-ээр илэрхийлж, “-n”-ээр үйлдэхийн тийн ялгалыг илэрхийлдэг. Гэхдээ зарим тохиолдолд “-n” мөн харъяалахын тийн ялгалаар хэрэглэгддэг. Жишээлбэл: *tāmġġn tuġraġ urtim* - *Тамичин (хаан)-ы*¹⁷ *тамгыг сийлсэн би*; *akin ara* - *хоёрын завсар*¹⁸ гэх мэт.

“-n” нь ихэнхдээ үйлдэхийн тийн ялгалын утгыг илэрхийлдэг байтал яагаад зарим үед харъяалахын тийн ялгалын үүргийг гүйцэтгэдгийг эдүгээ хараахан тайлбарлаж чадахгүй байсаар. Von Gabin гуай хэдийгээр “-n”-ийн энэ онцгой хэрэглээний байдлыг анхааралдаа авсан ч зөвхөн “зарим тохиолдол”-д гэдэгтээ багтаан тайлбарласан байна.¹⁹

qur(i)čġn - гэх үгийг бид “сахигчийн” хэмээн орчуулсны учир нь уг бичээсийн оршин байгаа газар буюу Дархан муумянган хошууны нутаг нь тухайн үеийн Түрэгийн хаант улсын өмнө хил байсан. Тэнд хил хязгаарыг сахин суух цэрэг анги байх нь мэдээж. Газар орны байдлыг ажихад ч түрэгийн үед холбогдох булш бунхан маш олон тохиолдох нь тус газарт Түрэгүүд оршин амьдарч байсны тод гэрч болж өгнө. Өгүүлэн буй бичээст хад маань ч үүний бас нэгэн нотолгоо мөн.

mGtib - **bit(i)g(i)m**: Эндээс “**bitig**” гэх нэр үг нь эртний түрэгийн сурвалж бичгийн аль ч үед байнга тохиолддог бөгөөд “*бичиг*” гэсэн утгатай бөгөөд Алтай язгуурын олон

¹¹ 包文胜: 《铁勒历史研究》, 博士论文, 2008年, 第123页。

¹² Л.Болд, *Орхон бичгийн дурсгал*, III, УБ, 2010. 57-р тал.

¹³ Ц. Баттулга, *Монголын бага дурсгалууд*, тэргүүн дэвтэр, УБ, 2005. 178-181-р тал.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Ц. Баттулга, *Монголын бага дурсгалууд*, тэргүүн дэвтэр, УБ, 2005. 115-121-р тал.

¹⁶ 韩儒林主编: 《元朝史》(上), 人民出版社, 北京, 2008, 第81-82页。

¹⁷ Л.Болд, *Орхон Бичгийн Дурсгал*, II, УБ, 2006. 246-р тал.

¹⁸ 耿世民: 《古代突厥文碑铭研究》, 中央民族大学出版社, 2005, 第120页。

¹⁹ 冯·加班著, 耿世民译: 《古代突厥语语法》, 内蒙古教育出版社, 2004, 第91页。

хэлтнүүдэд одоог хүртэл хэрэглэгдсээр байгаа билээ.²⁰ Бай Юй Дун уг бичээсийн 9-р үсэг “S” гэх түрэг үсгийг “-s” хэмээн уншсаныг бид “t” үсгийг “t” хэмээн уншсан билээ. Үүний шалтгаан нь уг бичээсийн дээд талаас үсгийн доод хөвөөг дагаад олон жилийн хур борооны ус урссан мэдэгдэм ором буй. Чухам энэхүү ормоос болж “t” үсгийн доод талын хэсэг нь замхарсан гэж үзэхэд хүргэж байна.

(-m) нь I биед хамаатуулах нөхцөл. “bitig”-ийн араас **bitigim** хэмээн залгавал “*бичиг минь*” гэсэн утгатай болно.

Бичээсийн 7, 8-р үсгийн хооронд нэгэн үл танигдах зурлага буй. (Зураг 3) Энэ зурлага нь хэмжээний хувьд бичээсээс бараг хоёр дахин том бөгөөд өнгө, байдлыг ажиглахад бичээстэй хамт сийлсэн нь илэрхий. Мөн түүнчлэн уг зурлагын дээд талд зэрэгцээ гурван хөндлөн зураас байсны хамгийн дээд талынх нь баларшсан байна. Куль-Тегиний хөшөөний дээд талд байх янгир ямааны зургийг Түрэгийн хааны угсаа болох Ашина овгийн тамга хэмээсэнтэй адилаар,²¹ судлаачид ер нь бичээстэй хамт гардаг үл танигдах зурлагыг бичээсэнд тэмдэглэсэн буюу бичээсийг сийлсэн хүний овог гарлыг заасан тамга гэж үздэг. Цагаан Овооны бичээст буй энэхүү зурлага нь М. Шинэхүү абугайн өгүүлсэн Хангидайн хадны бичээс²² дэх тамгатай их л төстэй. Иймээс энэ хоёр тамга ямар нэг талаар холбоотой буюу хоёр бичээсийг тэмдэглэсэн хүн нэг овгийнхон байж магад гэсэн таамаглалыг бидэнд төрүүлж байна. Юутай ч “Цагаан овооны бичээс”-т буй тус үл танигдах зурлагаас үзэхэд бичээсийг хаднаа сийлсэн хүн нь qu(ᠢ)ᠰᠢ гэх овгийн хүн, зурлага нь qu(ᠢ)ᠰᠢ овгийн тамга болох магадгүй.

Товч дүгнэлт

“Цагаан овооны бичээс” нь Өвөр Монголоос олдод байгаа цорын ганц эртний түрэг бичээс бөгөөд “qu(ᠢ)ᠰᠢn bit(i)g(i)m” хэмээсэн 11 үсгээр бүрэлдсэн “*Сахигчийн бичиг минь*” гэх утгатай бичээс.

Уг бичээст тодорхой хүний нэр, түүхэн хэрэг явдал буюу он цагийг дурдаагүй тул, бичигдсэн цаг хугацааг тодлох боломжгүй билээ. Бидний судалгаа зөвхөн үүгээр зогсохгүй цаашид үргэлжлүүлэн судлах болно.

НОМЗҮЙ

²⁰ 《中国突厥语族语言词汇集》，民族出版社，1990，第180-181页；孙竹主编：《蒙古语族语言词典》，青海人民出版社，1990，第153页。

²¹ М.Шинэхүү, Хангидайн Хадны Түрэг Бичээсийг дахин нягталсан нь, Хэл Зохиол Судлал, XIII, fasc 8, УБ, 1979.

²² Мөн тэнд.

1. Ц. Баттулга, *Монголын бага дурсгалууд*, тэргүүн дэвтэр, УБ, 2005.
2. Л.Болд, *Орхон Бичгийн Дурсгал*, II, УБ, 2006.
3. Л.Болд, *Орхон бичгийн дурсгал*, III, УБ, 2010.
4. М.Шинэхүү, *Хангидайн Хадны Түрэг Бичээсийг дахин нягталсан нь*, Хэл Зохиол Судлал, XIII, fasc 8, УБ, 1979.
5. G. Clauson, *An etymological dictionary of pre-thirteenth-century Turkish*, Oxford, Oxford University, 1972.
6. Bai, Yudong: *A translation of the čayan oby-a inscription written in the Turkic Runic script discovered in Inner Mongolia (Japanese)*, *Quaestiones Mongolorum Disputatae VI*, International Association for Study of Mongolian Cultures, Tokyo, 2010.
7. 《周书》(第三册)卷50《异域传》下突厥, 中华书局, 1971.
8. 麻赫默德·喀什噶里: 《突厥语大词典》(第一卷), 民族出版社, 2002.
9. 韩儒林主编: 《元朝史》(上), 人民出版社, 北京, 2008.
10. 《中国突厥语族语言词汇集》, 民族出版社, 1990.
11. 孙竹主编: 《蒙古语族语言词典》, 青海人民出版社, 1990.
12. 冯·加班著, 耿世民译: 《古代突厥语语法》, 内蒙古教育出版社, 2004.
13. 耿世民: 《古代突厥文碑铭研究》, 中央民族大学出版社, 2005.
14. 孟克德力格尔: 《达尔罕茂明安联合旗历史文化遗迹》, 内蒙古人民出版社, 2010.
15. 包文胜: 《铁勒历史研究》, 博士论文, 2008年.
16. 白玉冬、包文胜: “内蒙古包头市突厥鲁尼文查干敖包铭文考释——兼论后突厥汗国‘黑沙南庭’之所在”, 《西北民族研究》, 2012年第一期.


Хавсралт



Хавсралт зураг 1.



Хавсралт зураг 2.



Хавсралт зураг 3.

SUMMARY

“*Tsagaan ovoonii bichees/Inscriptions of White ovoo*” is the only ancient Turkic inscription found from Inner Mongolia and it has the meaning “*Sahigchyin bichig minu*” consisted of 11 letters as “*qur(i)čün bit(i)g(i)m*”.

No certain personal names, historical events and dates were mentioned in this inscription, thus it is impossible to determine its written date. The further studies are in progress.